

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 5

1. *Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал*

4 - 5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2025 оны 01 дугаар сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 42 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ,
Н.Номтойбаяр, Н.Учрал, О.Цогтгэрэл;
Эмнэлгийн чөлөөтэй: Ө.Шижир, Ж.Баярмаа, Л.Гантөмөр.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, ахлах мэргэжилтэн А.Наранцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдээр санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Уг асуудлыг 16 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 42 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаараа хэлэлцүүлнэ гэж заасан.

Тийм болохоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр дахь санал хураалт.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Гурав. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 01 сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 15 гишүүнээс 10 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүдэд. /алх цохив/

Хуралдаан 04 минут үргэлжилж, 16 цаг 46 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД